



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/42

Шивээговь сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.7, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам”-ын 5.1.4, 5.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Шивээговь сумын 2 дугаар баг, 21 дүгээр зөвлөгт хаваржиж буй малчин РД:ХБ87111210 дугаартай Эрдэнэгэрэлийн Тэмүүжингийн суурьт 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Дорнговь аймгийн Хатанбулаг сумын 2 дугаар багийн эргэл гэх газраас малчин РД:ЕЛ88121513 дугаартай Цэндсүрэнгийн Төмөртогоо нь 20 хонь, 40 ямаа, бүгд 60 толгой бол мал отор нүүдлийн зөвшөөрөлгүй, мал эмнэлгийн Meg5067347 дугаартай гэрчилгээтэй ирсэн тул 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

1.Тус нутаг дэвсгэрт хязгаарлалт тогтоож, малын шилжилт хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн гаргах, оруулах зэргийг хориглож ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (Ч.Отгонсүрэн), 2 дугаар багийн Засаг дарга (Д.Маналмаа) нарт даалгасугай.

2.Хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэр дэх малд үзлэг хийх, хашаа хорооны ариутгал халдвартгүйтгэл хийхийг “Хийморь алтай групп” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (А.Цэрэндолгор)-д даалгасугай.

3.Хязгаарлалтын дэглэм тогтоосон газар, бэлчээрийн ойролцоо байгаа малчин, мал бүхий иргэд хязгаарлалтын дэглэмийг мөрдөх, захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Джиншиг П.ГАНЧИМЭГ

42123 121